



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/217

Увс

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 03 сарын 29-ны өдрийн 109 дүгээр "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын (хуучнаар) төрийн үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа 8208001707 нэгж талбарын дугаартай 1732 м2 газрын эрхийг аймгийн Шүүх шинжилгээний хэлтэст (3245616)-т шилжүүлж, байршлыг хавсралтаар баталж, 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн байгууллагын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/226 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дүгээрт бичигдсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



